



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2025 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам
(САИНН)-ын дүрмийн өөрчлөлтийг
бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, Э.Золзаяа, Ц.Оч, Б.Ундрах, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, М.Пүрэвсүрэн, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Н.Баярмаагийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын үүсгэн байгуулагч Б.Жагараас “Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн намын дүрэмд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх тухай” өргөдлийг 176 хуудас материал, 1 ширхэг флашны хамт 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн байна.

Дээрх өргөдөл, хавсралтаар ирүүлсэн баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 06 дугаар тогтоолоор баталсан Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын дагуу шалгаж, нийт шүүгчийн хуралдаанд оруулсан болно.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрмийн өөрчлөлтийг дараах үндэслэлээр бүртгэхээс татгалзаж шийдвэрлэлээ.

Нэг. Намын дүрмийн өөрчлөлт нь хуульд нийцээгүй тухайд:

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын 2025 оны Ээлжит бус Их хурлын 10 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолоор намын дүрэмд өөрчлөлт оруулан баталж, Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтэд нийцүүлэн бүртгүүлэхээр ирүүлсэн гэх боловч дүрмийн зарим зүйл заалт нь хуулийн шаардлагад нийцээгүй, зөрчилтэй байна.

1.1. Улс төрийн намын тухай хуулийн /цаашид “Хуулийн” гэх/ 17 дугаар зүйлийн 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” нь Намын удирдах дээд байгууллагын онцгой бүрэн эрхэд хамаарахаар зохицуулсан.

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын өөрчлөлт оруулсан дүрмийг судалж үзвэл, намын дүрмийн 7.2.16-д “Намын Их хурлын чөлөөт цагт намын дүрэм, мөрийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах асуудлыг Бага хурлын гишүүдийн гуравны хоёроос багагүй гишүүдийн саналаар шийдвэрлэн батлах”-аар заасан байна. Дүрмийн 7.1-д зааснаар Бага хурал нь тус намын төлөөллийн төв байгууллага байх бөгөөд Хуулийн 17 дугаар зүйлийн зохицуулалтаас үзвэл дүрмийн гуравны нэгээс хэтэрсэн хэмжээгээр өөрчлөлт оруулах эсэх асуудал болон намын мөрийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах эсэх асуудал нь намын удирдах дээд байгууллагын онцгой бүрэн эрхэд хадгалагдаж байна. Өөрөөр хэлбэл, хуульд тухайлан заасан уг бүрэн эрхийг өөр байгууллагын эрх хэмжээнд шилжүүлэх боломжийг хуулиар олгоогүй. Иймд мөрийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах намын удирдах дээд байгууллагын онцгой бүрэн эрхийн асуудлыг намын төлөөллийн төв байгууллагад шилжүүлсэн нь хуульд нийцээгүй гэж үзнэ.

1.2. Намын дүрмийн 7.4.7.6-д “Намын бага хурлын гишүүнийг чөлөөлөх санал хураалтыг энэхүү дүрмийн 7.3.6 дахь заалтын дагуу явуулах бөгөөд бага хурлын гишүүдийн олонх огцруулах саналыг дэмжсэн тохиолдолд огцорсонд тооцно” гэж зохицуулсан нь ойлгомжгүй, хэм хэмжээ хэрэглээний тодорхой бус байдал үүсгэх үр дагавартай байна. Тодруулбал, бага хурлын гишүүнээс “чөлөөлөх” эсэх асуудлыг хэлэлцэж санал хураасан нь огцруулах үр дагаварт хүргэх боломжгүй. Иймд томъёолол ойлгомжгүй, өөр хоорондоо зөрчилтэй, нэг мөр ойлгон хэрэглэхэд бэрхшээл үүсгэхээр байна.

Намын дүрмийн 13.8-д “Намын хяналтын хорооны гишүүнийг огцруулах, чөлөөлөх”, 13.8.1-д “Энэхүү дүрмийн 3.5, 3.6-д зааснаас бусад тохиолдолд намын хяналтын хорооны гишүүнийг чөлөөлөхийг хориглоно”, 13.8.2-т “Намын хяналтын хорооны гишүүн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ өгөх эрхтэй” талаар дурдсан боловч огцруулах үндэслэлийг нэрлэн заагаагүй байна. Намын гишүүн болон намын дотоод нэгжийн байгууллагын гишүүнээс “огцруулах”, “чөлөөлөх”, “хасах” асуудлуудыг ялган зааглаж дүрмээ боловсруулах нь зүйтэй.

1.3. Хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т “намын дүрмийг санаатай зөрчсөн, эсхүл намын үнэт зүйл, зарчмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд намын гишүүнээс хасахыг хориглоно” гэж заасан.

Намын шинэчилсэн дүрмийн 3.5-д санаатай зөрчлийг жагсаан тогтоосон боловч “ноцтой зөрчил”-ийн хүрээ хязгаарыг хуульд заасан шалгуураар хэмжихээр нээлттэй үлдээсэн гэж үзэхээр байна. Практикт намын гишүүн ноцтой зөрчил гаргасан эсэх асуудлаар маргаан үүсэх бол Хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т тогтоосон “намын үнэт зүйлийг ноцтой зөрчсөн эсэх”, “намын зарчмыг ноцтой зөрчсөн эсэх” шалгуурыг харгалзан үзэхээр байна. Энэ тохиолдолд намын үнэт зүйл болон зарчим тодорхой байх шаардлага үүсэхийг дурдах нь зүйтэй.

Тус намаас 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр ирүүлсэн дүрмийн төсөлд ноцтой зөрчлийг зааж байсан боловч 2025 оны 11 дугаар сарын 08-ны өдрийн намын Ээлжит бус Их хурлын 25/06 дугаар

тогтоолоор намын дүрмээ шинэчлэн батлахдаа энэ талаар тусгайлан зохицуулаагүй байна. Ноцтой зөрчлийг тухайлан нэрлэн заах эсэх нь намын бүрэн эрхийн асуудал байж болох ч дээр дурдсан үндсэн шалгуураар хэмжигдэж болохуйц байдлаар дүрмийг боловсруулах нь зүйтэй.

1.4.Намын дүрмийн 9.2.1-д “Удирдах Зөвлөлийг намын Ерөнхий нарийн бичгийн даргыг оролцуулан 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Бага хурлаас сонгоно” гэж заасан байна. Удирдах зөвлөлийн гишүүд нууц санал хураалтаар сонгогдохоор хуульд заасан нь хэн нэгэн этгээд албан тушаалын байдлаар шууд томилогдох боломжийг хязгаарлах зорилготой эсэхийг анхаарвал зохино. Өөрөөр хэлбэл, намын Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах зөвлөлийн гишүүн байх нь зайлшгүй тохиолдолд нууц санал хураалтын зорилго алдагдах үр дагавартай. Энэ үүднээс дүрмийн 9.2.1 дэх заалт Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1-д заасан бүтцийн байгууллагыг нууц санал хураалтаар байгуулах шаардлагад нийцээгүй гэж үзэхээр байна.

1.5.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т “намын гишүүнээр элсэх, намын гишүүнээс түдгэлзэх, намын гишүүний эрх, үүрэг, намын гишүүнээс хасах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл”-ийг намын дүрэмд тусгахаар заасан.

Намын дүрмийн 3.1.2-т “Намын дүрэмд заасны дагуу түдгэлзэх, түдгэлзүүлсэн үндэслэл арилсан бол намын анхан шатны байгууллагад хүсэлтээ гаргаж гишүүнчлэлээ сэргээнэ. Намаас түдгэлзсэн нь намын гишүүн байсан нийт хугацаанаас хасагдахгүй”, 3.6-д “Намын гишүүнийг дараах тохиолдолд намын гишүүнчлэлийг Хяналтын хорооны шийдвэрээр түдгэлзүүлнэ”, 3.6.1-д “Намын гишүүн нь улс төрийн намын гишүүн байхыг зөвшөөрснөөс бусад төрийн албан тушаалд томилогдсон бол. Намын гишүүнээс түдгэлзэх бөгөөд, тухайн төрийн албан тушаалд томилогдсон тухайгаа намд бичгээр албан ёсоор мэдэгдсэнээр намын гишүүнээс түдгэлзсэнд тооцно” гэж заажээ. Дүрмийн 3.6.1 дэх заалтын эхний өгүүлбэрийг эс тооцвол намын гишүүнээс “түдгэлзэх үндэслэл”-ийг дүрэмд тодорхойлоогүй, эсхүл тодорхойлоход дэм болохуйц обьектив шалгуурыг бий болгоогүй гэж үзэхээр байна. Энэ нь намын дүрэм Хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй гэж үзэх үндэслэл болж байна.

1.6.Хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д “Намын санхүүгийн тайланг хянан шалгах нэг, эсхүл түүнээс дээш тооны дотоод аудиторыг намын төлөөллийн төв байгууллагаас дөрвөн жилийн хугацаатай томилно. Түүнийг нэг удаа улируулан томилж болно” гэж заасныг намын дүрмийн 7.2.34-т “Намын санхүүгийн тайланг хянан шалгах нэг дотоод аудиторыг 4 жилийн хугацаатай Бага хурлын гишүүний санал оруулснаар томилно. Дотоод аудиторыг нэг удаа улируулан томилж болно” гэж зохицуулсан боловч дотоод аудиторыг нөхөн томилох талаар дүрэмд тусгах нь зүйтэй.

1.7.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ”-г намын дүрмээр тусгайлан тогтоохоор заасан, үүний дагуу намын даргыг “сонгох”, “чөлөөлөх”, “огцруулах” үндэслэл, шийдвэр гаргах журмыг намын дүрмээр тус тусад нь тодорхой заах шаардлагатай.

Тус намын дүрмийн 8.6-д “Намын даргыг нөхөн сонгох”, 8.6.1-д “Намын даргад намын гишүүн нэр дэвших эрхтэй бөгөөд энэхүү дүрмийн 3.5, 3.6-д заасан зөрчилгүй байна” гэж тусгасан нь намын даргад хэрхэн яаж нэр дэвших журмыг тодорхойлсон зохицуулалт гэж үзэх боломжгүй байна. Мөн дүрмийн 8.7-д “Намын даргыг дараах үндэслэлээр чөлөөлөх болон огцруулах”, 8.7.1-д “Намын бага хуралд намын даргаас чөлөөлөгдөх саналаа бичгээр гаргасан мөн нас барсан эсхүл энэхүү дүрмийн 3.5, 3.6 дахь заалтад заасан нөхцөл байдал үүссэн бол намын даргыг чөлөөлөх бөгөөд энэхүү дүрмийн 6.6 дахь заалтыг баримтална”, 8.7.2-т “Намын ээлжит их хурал болон ээлжит бус их хурлын чөлөөт цагт энэхүү дүрмийн 3.5, 8.7.1-д зааснаас бусад тохиолдолд намын даргыг огцруулах, чөлөөлөхийг хориглоно” гэж чөлөөлөх, огцруулах үндэслэлийг ялган зааглаагүй нь хуулийн дээрх шаардлагад нийцэхгүй байна.

Хоёр. Бусад асуудлын тухайд:

2.1. Намын дүрмийн 8.3.10, 8.3.11 дэх заалтууд давхардсан байна.

Дээр дурдсан үндэслэлээр Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын дүрмийн өөрчлөлтийг бүртгэх боломжгүй байх тул холбогдох зөрчлүүдийг арилгасны үндсэн дээр Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн намын дүрмийг шинэчлэн баталж, хуульд заасан хугацаанд Улсын дээд шүүхэд дахин хандах эрхтэй болно.

Улсын дээд шүүхийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх шаардлага, шалгуурын талаар нэгдсэн, нэг мөр ойлголтыг дотоод ажлын хүрээнд бий болгох зорилгоор Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намын хувьд дүрэм, мөрийн хөтөлбөрийг шинэчлэн баталсан үйл ажиллагааг “Шалгах хуудас-1”, намын дүрэм, хөтөлбөр хуульд нийцсэн эсэхийг “Шалгах хуудас-2”-ын дагуу намуудаас ирүүлсэн өргөдлийг хянан шалгаж, Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын дагуу шийдвэрлэж байхаар тогтсон болохыг анхаарах нь зүйтэй.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасныг баримтлан Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрмийн өөрчлөлтийг бүртгэхээс татгалзсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Н.БАЯРМАА